



**НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот

**Байгууллагын дэргэдэх
“Залуучуудын хөгжлийн зөвлөл”
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 01 дугаар тогтоол, Монгол Улсын хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/72 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллага дахь залуучуудын хөгжил, оролцоог дэмжих, эрхийг хангах, салбар хоорондын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн үзэл бодлыг сонсох, хүндэтгэх, санал санаачлагыг дэмжих үүрэг бүхий сайн дурын үүсгэл санаачлагын үндсэн дээр бүрэлдсэн орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч	Б.Батцэцэг	Түлшний бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Э.Цогзолмаа	Төлөвлөгөө, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн
	Б.Адъяа-Очир	Оператор, техникч
	У.Жаргалбаатар	Оператор, техникч
Нарийн бичгийн дарга	Б.Оюунгэрэл	Диспетчер

2. Тушаалын хэрэгжилтийн ханган, зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлж ажиллахыг байгууллагын дэргэдэх “Залуучуудын хөгжлийн зөвлөл”-ийн гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ПҮРЭВСҮРЭН

1119282481.ш.5290031

Агтн/тушаал 2021/

1150500073